

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/89/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>
<i>МХЕГ</i>	<i>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</i>
<i>МХГ</i>	<i>Мэргэжлийн хяналтын газар</i>
<i>ХХОАТ</i>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА П.ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА

2021.02.24 № 2/78
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлсэн хяналт, шалгалтын үр нөлөө зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Албан хаагчдын цалин, томилолтын зардлыг зөрүүтэй тооцож олгосон, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа зарим албан хаагчдад олгосон цалин нотлох боломжгүй, шатахууны орлого, зарцуулалтын тайлан гаргаагүй, хандив тусламжийн орлогыг дутуу бүртгэсэн, анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",

021020339

гэж заасныг тус тус зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,515,728.70</u>	<u>87,356,978.58</u>
33	АВЛАГА	-	7,338,796.58
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		5,089,750
335	Бусад авлага	-	2,249,046.58
3351	Байгууллагаас авах авлага		2,249,046.58
35	БАРАА МАТЕРИАЛ	9,515,728.70	80,018,182
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,714,760.70	78,184,950
354	Хангамжийн материал	1,800,968	1,833,232
35410	Бичиг хэргийн материал	994,437	1,176,500
35420	Аж ахуйн материал	711,400	561,601
35470	Бусад хангамжийн материал	95,131	95,131
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,484,828,825.92</u>	<u>1,434,279,226.19</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,484,828,825.92	1,434,279,226.19
392	Биет хөрөнгө	1,464,532,025.92	1,413,982,426.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,282,063,203	1,282,063,203
39202	Хуримтлагдсан элэгдэл	54,088,099.68	76,808,841.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,723,412	91,723,412
39204	Хуримтлагдсан элэгдэл	91,723,412	91,723,412
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,456,047.80	163,456,047.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	123,327,817.04	146,230,457.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,410,059.10	11,410,059.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	9,781,566.76	10,682,100.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	772,625,993.60	849,838,093.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	580,018,414.10	659,063,577.59
393	Биет бус хөрөнгө	20,296,800	20,296,800
39303	Бусад биет бус хөрөнгө	20,681,800	20,681,800
39304	Хуримтлагдсан элэгдэл	385,000	385,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,494,344,554.62</u>	<u>1,521,636,204.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,008,448.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,008,448.50
413	Өглөг	-	3,008,448.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,773,448.50
4136	Бусад өглөг	-	1,235,000
41361	Байгууллагад төлөх өглөг		1,235,000
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,494,344,554.62</u>	<u>1,518,627,756.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,494,344,554.62	1,518,627,756.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	425,172,962	425,172,962
51101	Өмч: - төрийн	425,172,962	425,172,962
512	Хуримтлагдсан үр дүн	1,036,669,355.96	1,060,952,557.61
51210	Өмнөх үеийн үр дүн	1,036,669,355.96	1,036,669,355.96
51220	Тайлант үеийн үр дүн		24,283,201.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,502,236.66	32,502,236.66

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,494,344,554.62	1,521,636,204.77
---	--	-------------------------	-------------------------

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН/ /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,125,593,116.20	1,451,953,415
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,426,116.20	175,414,115
120	Нийтлэг татварын бус орлого	244,426,116.20	175,414,115
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	244,426,116.20	175,414,115
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,288,850	70,874,650
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	154,137,266.20	104,539,465
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,167,000.00	1,276,539,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,647,000	1,250,839,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,647,000	1,250,839,300
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,520,000	25,700,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,520,000	25,700,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,105,458,471.73	1,427,670,213.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,105,458,471.73	1,427,670,213.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,011,910,621.73	1,228,819,970.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	632,878,696	728,695,546.65
210101	Үндсэн цалин	524,543,796	528,471,796.16
210102	Нэмэгдэл	86,191,900	174,950,716.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,143,000	25,273,034.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,776,129	97,873,432.40
210201	Тэтгэврийн даатгал	52,963,125	84,635,701.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,022,303	3,326,175.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,984,759	2,667,888.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,252,189	658,515.21
210205	Эрүүл мэндийн даатгал	12,553,753	6,585,151.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,372,000	56,409,300
210301	Гэрэл, цахилгаан	9,843,290	8,678,600
210302	Түлш, халаалт	41,892,236	43,451,660
210303	Цэвэр, бохир ус	1,936,474	4,257,940
210304	Байрны түрээс	700,000	21,100
2104	Хангамж, бараа материалын зардал	39,523,413	75,519,868
210401	Бичиг хэрэг	10,403,556	16,776,900
210402	Тээвэр, шатахуун	18,347,155	36,461,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,652,702	12,324,800
210404	Ном, хэвлэл		2,192,620
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000	120,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000	7,644,548
2105	Нормативт зардал	26,882,900	23,476,600
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,465,000	21,226,600
210502	Хоол, хүнс	2,456,300	2,250,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,961,600	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,552,000	63,754,793.70
210604	Урсгал засвар	14,552,000	63,754,793.70
2107	Томилолт, зочны зардал	16,172,300	28,457,000
210702	Дотоод албан томилолт	16,172,300	28,457,000

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,839,515	28,089,350
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,905,930	23,410,850
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,825	651,500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000	110,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,902,850	1,905,000
210807	Газрын төлбөр	12,000	12,000
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,663,910	2,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,913,668.73	126,544,079.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,164,340	975,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,749,328.73	125,569,079.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,547,850.00	198,850,242.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,259,000	86,469,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		64,169,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,259,000	22,300,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,948,850	112,380,542.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,948,850	112,380,542.87
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	340,000	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	340,000	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,134,644.47	24,283,201.65

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	971,455,850	1,347,324,500
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,288,850	70,785,200
120	Нийтлэг татварын бус орлого	90,288,850	70,785,200
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,288,850	70,785,200
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,288,850	70,785,200
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,167,000	1,276,539,300
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,647,000	1,250,839,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,647,000	1,250,839,300
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,520,000	25,700,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,520,000	25,700,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	959,475,850	1,330,324,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	959,475,850	1,330,324,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,076,000	1,131,474,257.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,969,900	727,571,077.21
210101	Үндсэн цалин	523,635,000	527,347,326.72
210102	Нэмэгдэл	88,037,200	174,950,716.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,297,700	25,273,034.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,996,400	98,903,499.92
210201	Тэтгэврийн даатгал	78,996,400	85,665,769.02
210202	Тэтгэмжийн даатгал		3,326,175.91
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,667,888.12
210204	Ажилгүйдлийн даатгал		658,515.21
210205	Эрүүл мэндийн даатгал		6,585,151.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,432,500	56,409,300
210301	Гэрэл, цахилгаан	9,843,290	8,678,600
210302	Түлш, халаалт	41,892,236	43,451,660
210303	Цэвэр, бохир ус	1,996,974	4,257,940
210304	Байрны түрээс	700,000	21,100
2104	Хангамж, бараа материалын зардал	39,446,550	73,179,840
210401	Бичиг хэрэг	8,557,178	16,776,900
210402	Тээвэр, шатахуун	18,314,005	36,461,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,770,802	12,324,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000	120,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,684,565	7,497,140
2105	Нормативт зардал	16,776,600	23,476,600
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,220,300	21,226,600
210502	Хоол, хүнс	2,556,300	2,250,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,676,350	87,385,940
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000	76,286,540
210604	Урсгал засвар	12,676,350	11,099,400
2107	Томилолт, зочны зардал	16,472,300	32,792,300
210702	Дотоод албан томилолт	16,472,300	32,792,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,929,500.00	30,379,800
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,400,000.00	24,165,300
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	1,536,000
210803	Даатгалын үйлчилгээ	261,000.00	261,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	390,500.00	390,500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	110,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,805,000	1,905,000
210807	Газрын төлбөр	12,000	12,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,391,000	2,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,375,900	1,375,900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,375,900	1,375,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,399,850	198,850,242.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,111,000	86,469,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		64,169,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,111,000	22,300,000

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,948,850	112,380,542.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,948,850	112,380,542.87
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	340,000	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	340,000	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,980,000	17,000,000
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,980,000	17,000,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,980,000	17,000,000
2200	Дотоод эх үүсвэрээр	11,980,000	17,000,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,980,000	17,000,000
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,980,000)	(17,000,000)

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,172,962	43,933,756.66	1,025,237,835.96	1,494,344,554.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,172,962	43,933,756.66	1,025,237,835.96	1,494,344,554.62
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-11,431,520	11,431,520	-
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,172,962	32,502,236.66	1,036,669,355.96	1,494,344,554.62
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,172,962	21,070,716.66	1,048,100,875.96	1,494,344,554.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,172,962	32,502,236.66	1,036,669,355.96	1,494,344,554.62
D08	Тайлант үеийн үр дүн			24,283,201.65	24,283,201.65
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,172,962	32,502,236.66	1,060,952,557.61	1,518,627,756.27

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	868,647,000	868,647,000	1,250,839,300	1,209,243,957.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,647,000	868,647,000	1,250,839,300	1,209,243,957.13

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,536,000	865,536,000	1,183,558,600	1,141,974,257.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,969,900	631,969,900	747,828,100	727,571,077.21
210101	Үндсэн цалин	523,635,000	523,635,000	566,680,400	527,347,326.72
210102	Нэмэгдэл	86,191,900	86,191,900	140,762,400	174,950,716.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,143,000	22,143,000	24,805,000	25,273,034
210104	Урамшуулал			15,580,300	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,996,400	78,996,400	98,903,500.00	98,903,499.92
210201	Тэтгэврийн даатгал	53,717,442	53,717,441.50	68,413,500.00	68,990,375.92
210202	Тэтгэмжийн даатгал	6,319,699	6,319,699	7,622,500	7,478,281
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,055,759.20	5,055,759.20	6,098,000.00	5,982,624.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,263,939.80	1,263,939.80	1,524,500.00	1,495,656.20
210205	Эрүүл мэндийн даатгал	12,639,561	12,639,561	15,245,000	14,956,562
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,432,500	54,432,500	56,409,300	56,409,300
210301	Гэрэл, цахилгаан	7,613,400	9,843,290	8,678,600	8,678,600
210302	Түлш, халаалт	39,936,800	41,892,236	43,451,600	43,451,660
210303	Цэвэр, бохир ус	5,796,000	1,996,974	4,258,000	4,257,940
210304	Байрны түрээс	1,086,300	700,000	21,100	21,100
2104	Хангамж, бараа материалын зардал	39,010,700	39,010,700	72,360,000	72,179,840
210401	Бичиг хэрэг	7,246,800	8,557,178	16,776,900	16,776,900
210402	Тээвэр, шатахуун	18,341,800	17,774,005	35,461,000	35,461,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,624,800	10,874,952	12,324,800	12,324,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000	120,000	120,000	120,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,677,300	1,684,565	7,677,300	7,497,140
2105	Нормативт зардал	16,676,600	16,676,600	23,476,600	23,476,600
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,426,600	14,120,300	21,226,600	21,226,600
210502	Хоол, хүнс	2,250,000	2,556,300	2,250,000	2,250,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,643,200	13,643,200	119,718,400	98,885,940
210601	Багаж, техник, хэрэгсэл			17,000,000	17,000,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000	1,000,000	90,955,200	70,786,540
210604	Урсгал засвар	12,643,200	12,643,200	11,763,200	11,099,400
2107	Томилолт, зочны зардал	16,472,300	16,472,300	32,792,300	32,792,300
210702	Дотоод албан томилолт	16,472,300	16,472,300	32,792,300	32,792,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,958,500	12,958,500	30,694,500	30,379,800
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,400,000	6,400,000	24,480,000	24,165,300
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000	560,000	1,536,000	1,536,000
210803	Даатгалын үйлчилгээ	261,000	261,000	261,000	261,000

210804	Тээврийн хэрэгслийн татвар	390,500	390,500	390,500	390,500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000	110,000	110,000	110,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,905,000	1,905,000	1,905,000	1,905,000
210807	Газрын төлбөр	12,000	12,000	12,000	12,000
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,320,000	3,320,000	2,000,000	2,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,375,900	1,375,900	1,375,900	1,375,900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,375,900	1,375,900	1,375,900	1,375,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,111,000	3,111,000	67,280,700	67,269,700
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,111,000	3,111,000	67,280,700	67,269,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			64,169,700	64,169,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,111,000	3,111,000	3,111,000	3,100,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	868,647,000	868,647,000	1,250,839,300	1,209,243,957.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	868,647,000	868,647,000	1,250,839,300	1,209,243,957.13
131001	Улсын төсвөөс санхүүжих	868,647,000	868,647,000	1,250,839,300	1,209,243,957.13
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	59	63	61
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	43	39	43	41
620003	Үйлчлэх ажилтан	19	19	19	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	63	59	63	61
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	44	40	44	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	19	19

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,520,000	25,700,000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,000	25,700,000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,000	1,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	440,000	1,000,000
210402	Тээвэр, шатахуун	440,000	1,000,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000	24,700,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000	24,700,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000	24,700,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,980,000	-
2200	Дотоод эх үүсвэрээр	11,980,000	-

222001	Тоног төхөөрөмж	11,980,000	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,520,000	25,700,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,520,000	25,700,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,980,000	1,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,700,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	440,000	

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга П.Эрдэнэчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Тус байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулахаар түүвэрлэн хянахад эрсдэлтэй асуудлууд үүссэнээс шалтгаалан нийт данстын тооцооллыг давтан хийхэд цаг хугацаа, хүний нөөц хүрэлцэхгүй байгаа тул дараагийн шатанд дахин хяналт шалгалт хийх шаардлагатай байна.

Аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь тоон мэдээллийг тулган баталгаажуулахад гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй анхаарал хандуулахуйц асуудлууд илэрч, санхүүгийн тайлангийн ихэнх дансыг хамарч байгаа тул “Сөрөг” санал дүгнэлт гаргаж , Аймгийн Прокурорын газарт шилжүүлэн шалгуулах шаардлагатай зүйтэй гэж үзлээ.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 24-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул, гэрээт аудитор Б.Бадамцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мэргэжлийн хяналтын газар нь “Монгол улсын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар үндэсний аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдэд хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх ” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, норм норматив, стандартын хэрэгжилтийг хангуулах,
- Төрийн хяналтын чиг үүргийг иргэд олон нийтэд хууль эрх зүйн хүрээнд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх,
- Зөвлөн туслах, аливаа зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдсэн хяналт шалгалтын тайланг ирүүлээгүй болно.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1125593.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11255.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1441983.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 14419.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23475.7 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага		7,338.8	7,338.8
Бараа материал	9,515.7	80,018.2	70,502.5
Үндсэн хөрөнгө	1,484,828.8	1,434,279.2	(50,549.6)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,494,344.5	1,521,636.2	27,291.7

Богино хугацаат өр төлбөр		3,008.4	3,008.4
Цэвэр хөрөнгө, өмч	1,494,344.5	1,518,627.8	24,283.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,494,344.5	1,521,636.2	27,291.7

Авлага дансны үлдэгдэл 7338.8 мянган төгрөг болж өссөн шалтгаан нь томилолтын авлага 4335.3, ХХОАТатвар 1219.0, НДШимтгэл 1030.1, ариутгалын тооцооны авлага 754.4 мянган төгрөгийн авлагатай байгаагаас ариутгал тооцооны үнэн зөв илэрхийлэгдсэн нь тодорхой бус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80018.2 мянган төгрөг болж 70502.5 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчдын нормын хувцас худалдан авсан, МХЕГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн бараа материалаар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитаар бараа материалын тооллогын бүртгэл, бараа материалын орлого, зарлагын журналаас хөөн хянах боломжгүй байна. Тухайлбал: Бэлтгэн нийлүүлэгчээс авсан шатах тослох материал болон худалдан авсан, зарцуулсан эм урвалжийн тайлан тооцоог бүрэн бодоогүй, оны эцэст бараа материалын тооллого хийсэн талаарх нотлох баримтгүй, санхүүгийн программд бичиг хэргийн материалыг бөөн дүнгээр орлого авч зарлагдсан, зарим материал хасах үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2419172.6 мянган төгрөг болж 75019.5 мянган төгрөгөөр өссөн нь МХЕГ-аас 60212.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь МХЕГ-аас мананцаржуулагч, суурин термокамерийг үнэ төлбөргүйгээр 60212.1, төсвийн хөрөнгөөр 17000.0 мянган төгрөгөөр явуулын пост худалдан авч нэмэгдсэн байна.

Хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 859324.3 мянган төгрөг байсан тайлант оны элэгдлийн зардал 125569.1 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 984893.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1878 тоотой хөрөнгийн данс бүртгэлд байгаа 2192.6 мянган төгрөгийн ном, гарын авлагыг бараа материал руу шилжүүлэн бүртгэж, хөрөнгө актлаагүй, биет бус хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3008.4 мянган төгрөг болж өссөн нь 2010-2019 онд ажилласан даатгуулагчийн шимтгэлийн төрөл засуулах талаар НДЕГ-т хүсэлт гаргаснаас холбоотой нэмэгдэж, барагдуулах боломжтой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1518627.8 мянган төгрөг болж 24283.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 24283.3 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 395372.3 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн, үнэ төлбөргүй орлого 49597.8, үндсэн үйл ажиллагааны орлого 19414.2, бүгд 69012.0 мянган төгрөгийн орлого буурсан байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн санхүүжилтийн орлого нэмэгдсэн холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 322211.7 мянган төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 115914.1, тогтмол зардал 2037.3, хангамж бараа материалын зардал 35996.5, томилолтын зардал 12284.7, эд хогшил, урсгал засварын зардал 49202.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 15249.8, урсгал шилжүүлэг 105302.4 мянган төгрөгөөр тус тус өссөн, бараа үйлчилгээний бусад зардал 10369.6, норматив зардал 3406.3 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн нягтлан бодох бүртгэлийн заруулга бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1063036.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1063036.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1165795.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж 4 удаа тодотгож 1250839.3 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1250839.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1250839.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1209243.9 мянган төгрөгийг зарцуулж 41595.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1209243.9 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2025.0, хангамж, бараа материалын зардал 180.2, эд хогшил, урсгал засварын зардал 20168.7, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 314.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 41915.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой спортын үйл ажиллагаа явагдаагүйгээс хэмнэгдсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	41,589.9
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	314.7
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11.0
	ДҮН	41,915.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын 179 дүгээр тогтоолоор 19200.0, МХЕГазрын А/47 тоот тушаалаар 5500.0, аймгийн ИТХ-ын тоот тогтоолоор 1000.0 мянган төгрөг нийт 25700.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад нэг удаагийн хамгаалах хэрэгсэл худалдан авахад 5500.0, урамшуулалд 19200.0, шатахууны зардалд 1000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 131 мэдээллээс хугацаандаа оруулсан 115 мэдээлэл, 1 мэдээллийг мэдээлээгүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад 12 дугаар сарын тухай бүрд мэдээлэх 13 ажил гүйлгээ буюу Мо Эн Ко ХХК-аас 10 сард орлого, нэмэлт санхүүжилтийн орлого зарлага, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85192.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 18934.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулагдаагүй 66258.2 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 20243.4 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 1910.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, 44140.2 мянган төгрөгийн алдааг дараагийн аудитаар дахин хянах шаардлагатай гэж үзлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хилийн боомтын албан хаагчдад нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, уусмалыг үнэ төлбөргүй хүлээн өгсөн 9970.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгээгүй,
2. Мобинет ХХК-тай байгуулсан гэрээ, сар бүрийн төлбөрийн нэхэмжлэх болон бусад анхан шатны холбогдох баримтгүй 5148.0 мянган төгрөгийг төлсөн ажил гүйлгээний баримтуудыг аудитын явцад бүрэн бүрдүүлсэн,
3. Тайлант үеийн үр дүнг 3816.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж **18934.0** мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 66258.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 20243.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 44104.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг анхаарал татахуйц асуудалд тусгасан хүргүүллээ. Үүнд:

1. МХГ-ын даргын тушаалаар хүүхдээ асрах чөлөөтэй байгаа албан хаагчдад 9-10 сард цалин бодож олгосон, эд хариуцагчийн харилцах данс руу томилолтын урьдчилгаа олгоод нягтлан бодогчийн данс руу шилжүүлсэн, сахилгын арга хэмжээг суутгаагүй, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулалд **10597.1** мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр

тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.6-д "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", гэсэн заалттай нийцээгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

2. Албан хаагчдын төрийн алба хаасны нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг тушаалд заасан хувиас дутуу, хилийн боомтод 12 сард илүү цагаар ажилласан ажилчдын илүү цагийн хөлс **2045.1** мянган төгрөгийг бодож олгоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2-д "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно", газрын дотоод журмын 6.3-д "долоо хоногийн амралтын өдөр болон илүү цагаар ажилласан албан хаагчийг нөхөн амруулаагүй бол цалин хөлсийг 1.5 дахин, нийтээр амрах баярын өдөр ажилласан албан хаагчийг нөхөн амруулаагүй бол цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно" гэсэн заалтуудтай нийцээгүй аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан олгох төлбөрийн акт бичих

3. Хөрс шатахуун түгээх станцаас шатах тослох материалыг 1 литрийг зах зээлийн үнээс 260-280 төгрөгөөр өндөр үнээр худалдан авсан **1280.9** мянган төгрөг, томилолтоор ажилласныг нотлох боломжгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 1985.0 мянган төгрөг, оны эцэст томилолтын урьдчилгаанд 4335.3 мянган төгрөгийг тусгасан боловч хуурамч баримт бичиг бүрдүүлсэнтэй, нийт 7601.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 3.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1910.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээлэл нь үнэн зөв илэрхийлэгдснийг нотлох боломжгүй нь анхаарал татахуйц дараах асуудлуудыг дараагийн аудитаар эрсдлийн аудит болгон авч үзэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Сар бүрийн цалингийн тооцоог нягтлан бодогчийн бодсноос түүвэрлэн тулгахад зарим саруудад албан хаагчдын цалинг зөрүүтэй олгосон,
- Эд хариуцагчийн ХААН банканд дахь 5845472818 тоот дансны руу 2020 онд нийт 10449.0 мянган төгрөгийг бараа материалын үнэ, албан хаагчдаас суутган авсан хандивын мөнгийг шилжүүлсэн боловч холбогдох материалын үнэ болон хандивыг олгох байгууллага, хувь хүмүүст олгоогүй, газрын нягтлан бодогч болон зарим албан хаагчдын данс руу шилжүүлсэн,
- Тайлант онд 35240.0 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авсан, зарцуулалтын тайлан гаргаагүй, төлбөрийг төлөхдөө бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн төлбөрийг төлсөн, газрын дарга нь шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг өөрөө олгож эд хариуцагч нь газрын даргын шатахуун олгосон бичгийг түүвэрлэн жагсаалт үйлдэн санхүүгийн баримтад хавсаргасан, шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг оны эхнээс дугаарлаагүй, дотоод хяналтгүй зарцуулсан,
- Ариутгал халдваргүйтгэлтэй холбоотой эрсдэл үүсэж дотоод хяналт хэрэгжүүлж зөрчил илэрсэн ч албан хаагчдад арга хэмжээ авсныг дахин хянаагүй,
- Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа албан хаагчдад газрын даргын тушаалаар чөлөөний хугацаа дуусахаас өмнө Улсын онцгой комиссын шийдвэрийг үндэслэн цахимаар ажиллуулахаар тушаал гаргаж 11.12 дугаар сарын цалинг олгохдоо тухайн ажилтны харилцах данс руу сарын цалинг шилжүүлсэн боловч уг албан хаагч нь өөрийн данснаас нягтлан бодогчийн болон бусад ажилчдын данс руу шилжүүлсэн зөрчил илэрч аудитын явцад тухайн ажилтнаас тодруулахад хувийн тооцооны авлага, өглөг байсан гэсэн тайлбар өгч байгаа тул нотлох боломжгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээлэл нь үнэн зөв илэрхийлэгдснийг нотлох боломжгүй, байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, тайланд залруулга хийгдээгүй материалыг хэмжээний алдаа зөрчил илэрлээ. Зөрчлийн нэгтгэлд дурдсан болон анхаарах хандуулахуйц асуудлын хэсэгт бичсэн алдаа зөрчилд дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.
- 1.2. Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах,
- 1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт

шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: МХГ-ын даргын 2015 оны А/35 дугаар тушаалаар “Даргын зөвлөлийн журам”-ын 7.1-д “ Мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуралдаанд оролцсон байдлыг харгалзан зохих урамшуулал олгож болно” гэсэн заалтыг үндэслэн дүгээр зааснаар гэсэн заалтыг үндэслэн албан хаагчдад урамшуулал олгосон байна.

2.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөөгүй тул холбогдох журмын заалтыг өөрчлөн ажиллах

2. 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны холбогдох мэдээллийг мэдээлээгүй 2020 оны 12 дугаар сарын мэдээлэл, батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлээгүй, нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагыг байршуулаагүй байна.

3.2. Эрсдэл: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтыг мөрдөөгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.5.4-д “улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/89/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Мэргэжлийн хяналтын газар

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Хүүхдээ асрах чөлөөтэй байсан албан хаагчдад цалин олгосон, цалингийн урьдчилгааг олгоод суутгаагүй, авлагаар тусгаагүй, сахилгын арга хэмжээг бүрэн суутгаагүй, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	10597.1	Төлбөрийн акт		
2	Албан хаагчдын 1-р улирлын нэмэгдлийг дутуу олгосон, хил дээр ажиллаж байгаа албан хаагчдын 12 сарын илүү цагийн мөнгийг олгоогүй	2045.1	Төлбөрийн акт		
3	Хөрс шатахуун түгээх станцаас шатах тослох материалыг 1 литрийг зах зээлийн үнээс 260-280 төгрөгөөр өндөр үнээр худалдан авсан 1280.9 мянган төгрөг, томилолтоор ажилласныг нотлох боломжгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 1985.0 мянган төгрөг, оны эцэст томилолтын урьдчилгаанд 4335.3 мянган төгрөгийг тусгасан боловч хуурамч баримт бичиг бүрдүүлсэнтэй	7601.2	Төлбөрийн акт	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
4	Эд хариуцагч нь тухайн сард худалдан авсан болон зарцуулсан шатах тослох материалын тайлан гаргадаггүй. Газрын дарга нь өөрөө шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг олгодог, тухайн сарын эцэст эд хариуцагч нь жолооч бүрээр олгосон шатахууны жагсаалт гардаг дутагдал зөрчил илэрлээ.	35240.0	Дараагийн аудитаар дахин хянах		
5	Санхүүгийн программд бараа материалыг шивж оруулахдаа нэр төрлөөр нь орлогод аваагүй бөөн дүнгээр орлогодсон, зарлагыг гаргахдаа хасах тэмдэгтэй зарлагдсан нь материалын худалдан авалт зарцуулалтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон нэр төрлөөр хөөн хянах боломжгүй, бараа материал худалдан авахдаа И баримт авахгүйгээр худалдан авсан зэрэг зөрчил илэрлээ.	0	Дараагийн аудитаар дахин хянах	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
6	Мо Эн Ко ХХК, Эй Эйл Жи ХХК, Вестерн холдинг ХХК-аас Ковид-19 цар тахалтай холбоотой хилийн боомтын албан хаагчдад нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, уусмалыг үнэ төлбөргүй хүлээн өгснийг бүртгээгүй орхигдуулсан	9970.0	Залруулга хийх	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
7	Тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	3816.0	Залруулга хийх		
8	Сар бүрийн цалингийн тооцоог нягтлан бодогчийн бодсоноос түүвэрлэн тулгахад зарим саруудад албан хаагчдын цалинг зөрүүтэй олгосон	8864.2	Дараагийн аудитаар дахин хянах	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
9	2020 онд Мобинетийн сар бүрийн төлбөрийг төлөхдөө анхан шатны баримтгүй төлсөн,	5148.0	Залруулга хийх	дарга , ня- бо	

	аудитын явцад 2016 оны 12 дугаар сард Мобинет ХХК, МХЕГ-тай хийсэн интернэт үйлчилгээний гэрээг ирүүлсэн. Гэрээний ашиглалт тодорхой бус				П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
10	МХГ-ын 2015 оны А/35 дугаар тушаалаар "Даргын зөвлөлийн журам"-ын 7.1 дүгээр зааснаар гэсэн заалтыг үндэслэн албан хаагчдад урамшуулал олгосон нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан	1910.6	Зөвлөмж өгөх	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
11	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 12 сард мэдээлэх мэдээллийг байршуулаагүй, батлагдсан төсөвт 4 удаа өөрчлөлт орсон боловч мэдээлээгүй, нэмэлт дансны орлого зарлагыг байршуулаагүй	0	Зөвлөмж	дарга , ня- бо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
12	Дотоод хяналтын баг томилон аудитаар илэрсэн зөрчилд дахин хяналт шалгалт хийх шаардлагатай байна.		Зөвлөмж	Дарга, нябо	П.Эрдэнэчулуун Н.Баянжаргал
ДҮН		85192.2			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Огноо:2021. 02.24

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо: 2021. 02.24

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

Огноо: 2021. 02.24

ГЭРЭЭТ АУДИТОР

Б.БАДАМЦЭЦЭГ

Огноо: 2021. 02.24